

**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ 2023 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь: Компанийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

**БҮРЭЛДЭХҮҮН:**

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-Эрдэнэ

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Бархасбадь

ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Бакей

Нэр дэвшүүлэх хороо нь 2 удаа хурал зохион байгуулж, хэлэлцсэн асуудалтай холбоотой дүгнэлт гаргаж, ТУЗ-д хурлын үр дүнгээ танилцуулсан бөгөөд хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажилласан.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх дуусгавар болж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтыг зарлан олон нийтэд мэдээлж, шаардлага хангасан нэр дэвшигчийн материалыг ТУЗ-д танилцуулж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр төлөвлөж байна.

**ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх нь:**

Нэр дэвшүүлэх хорооноос дэвшүүлэн ХЭЭХ-аас сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь бүрэн эрхийнхээ хугацаанд буюу 2022 оны 05-р сарын 17-ний өдөр анхдугаар хуралдаанаа хийснээс хойш 2024 оны 03-р сарын 11-ны өдрийг дуустал нийт 11 удаа / 3 удаа биечлэн, 4 удаа цахим, 4 удаа эчнээ/ хуралдсан бөгөөд эдгээр хурлаар хэлэлцсэн асуудлыг нэгтгэвэл:

- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан танилцуулсан тухай 10 шийдвэр,
- Арилжааны банкнаас зээл авах, эрх баталгаажуулах тухай 6 шийдвэр,
- Дүрэм журам, бодлогын бичиг баримт батлах, дүгнэлт гаргах, үүрэг даалгавар өгөх, бусад асуудлыг хэлэлцсэн тухай шийдвэр нийт 31 асуудал шийдвэрлэж, үнэлэлт өгч ажиллажээ.

- Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцсон байдлыг авч үзвэл:

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2022 он	2023 он	2024 он	Нийт оролцоо	Ирцийн хувь
		/4 удаа/	/5 удаа/	/2 удаа/		
Хурлын оролцсон тоо						
1	Л.Эрхэмбаяр	4	5	2	11	100%
2	Б.Тунгалаг	4	3	2	9	83.3%
3	Ж.Болд	3	5	2	10	91.6%
4	Э.Баяржаргал	4	5	2	11	100%
5	Б.Бархасбадь	4	4	1	9	83.3%
6	Э.Жаргалхүү	4	5	2	11	100%
7	А.Бакей	4	5	2	11	100%
8	Г.Мөнх-эрдэнэ	2	5	2	9	83.3%
9	Ц.Наран-Учрал	4	5	2	11	100%



Нэр дэвшүүлэх хороо нь компанийн тогтвортой үйл ажиллагааг өндөр чадвартай удирдлага, зохион байгуулалтаар тасралтгүй хангах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Эрх бүхий албан тушаалтнуудын нөөцийг бүрдүүлэх, тухайн албан тушаалын зэрэглэлтэй уялдуулж сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшуулал, залгамж халааг бэлтгэхэд анхааран ажиллаж, ТУЗ-ийн хурлаар компанийн “Залгаж халааны бодлого”-ыг хэлэлцүүлэн батлуулсан.

***Компанийн гүйцэтгэх удирдлагад үнэлэлт дүгнэлт өгөх нь:***

Компанийн гүйцэтгэх удирдлага нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлэн компанийн үйл ажиллагааны тасралтгүй хэвийн байдлыг ханган ажиллаж, шувууны аж ахуйн бүтээн байгуулалтыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгүүлэн ашиглалтанд оруулж чадсанаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Компанийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй нягт хамтран ажиллаж, ТУЗ-ийг байнга мэдээллээр хангаж, байгууллагын санхүү болон үйл ажиллагааны тайлан мэдээллийг холбогдох журамд заасны дагуу нээлттэй, ил тод, тэнцвэртэй байдлыг хадгалан цаг тухайд нь олон нийтэд хүргэх зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.

***ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажилд үнэлэлт дүгнэлт өгөх нь:***

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлын мэдээлэл, хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох танилцуулга материалыг цаг тухай бүрт нь бэлтгэн боловсруулж, хурлыг зохион байгуулахын зэрэгцээ Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах ажлыг зөв зохион байгуулан ажилласан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, ТУЗ болон дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэр, дүгнэлтийг зохицуулах байгууллага болон олон нийтэд мэдээллэх, бичиг баримтын бүртгэл хөтлөх, хурлын тэмдэглэл бичих зэрэг хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зөв зохион байгуулж ажилласан гэж дүгнэж байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА ..... Г.МӨНХ-ЭРДЭНЭ

